

ХЯНАЛТ ШАЛГАЛТААР

2020.06.27

Хутаг-Өндөр сумын ЕБС, Уньт, Хантайн бага сургуульд хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтаар цалингийн зардлаас 414,0 мянган төгрөгийн албан томилолт олгосон, 1786,8 мянган төгрөгийн урамшуулал давхар олгосон, 518,7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл шийдвэргүй олгосон, 1110,8 мянган төгрөгийн цалин илүү олгосон, 4353,2 мянган төгрөгийн цалин дутуу олгосон, 500,0 мянган төгрөгийн урьдчилгааг дутуу суутгасан, 86,1 мянган төгрөгийн материалын үнэ илүү шилжүүлсэн, шийдвэр нь гарсан байхад олгоогүй ур чадварын нэмэгдэл 693,4 мянган төгрөг нийт 9463,5 мянган төгрөгийн төлбөр тогтоож, илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага өгөв.

Булган сумын ИТХ, ЗДТГ, Ойн анги, Номын сан, Музейд төлөвлөгөөт хяналт шалгалт үргэлжилж байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлыг бүх сум байгууллагуудад АБЛЕ-ээр хүргүүлэв.

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас Хишиг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитаар эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас Шүүхийн шийдвэрийн дагуу Засаг даргын Тамгын газрын ажилтан Г.Оюунцэцэгт 2018-2019 оны ажилгүй байх хугацааны нийт 5461433 /Таван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун гучин гурав/ төгрөгийн цалинг байгууллагаас төлж, байгууллагын хохирлыг барагдуулаагүй зөрчилд ирүүлсэн албан шаардлагын дагуу улсын ахлах байцаагч төлбөрийн акт тогтоож гардуулав.

2019 онд хяналт шалгалтаар тогтоогдсон төлбөрийн актуудын биелэлтийг тооцож аймгийн Прокурорын газарт өгөв.

. 2019 онд хяналт шалгалтаар тогтоогдсон төлбөрийн актуудын биелэлтийг тооцож аймгийн Прокурорын газарт өгөв.

БЭЛТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Д.САРАНГЭРЭЛ

